



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/104

Цагаан-Уул сум

Шинжилгээнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтаны эрүүл мэндийн тухай хуулийн 23.4, 23.5, Мал эмнэлэгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/104 дугаар тушаал Хөвсгөл аймгийн Засаг даргын А/354 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын бруцеллэз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд азарганаас бусад хээлтүүлэгч малд бруцеллэз өвчний тандалт шинжилгээг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 07 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж ажилласугай.

2. Тандалт шинжилгээнд хамрагдах малын тоо, шаардагдах оношлуур, хэрэглэгдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Шинжилгээнд шаардлагатай хүн хүч, машин техник, шатахуун бусад зардалыг шийдвэрлүүлж, холбогдох тайлан мэдээг нэгтгэж Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Мал эмнэлэгийн тасгийн дарга, Улсын байцаагч (Т.Чандмаа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/